



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/035/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Алтантуяа

Утас: 7033-3019

Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 41
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
О.ЖАВЗАНСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Эрдэнэбулган сумын Засаг даргын 2024 оны "Албан хаагчдад шагнал олгох тухай" Б/172 тоот захирамжаар албан хаагчдад 19,133.0 мянган төгрөгийн шагналыг батлагдсан цалингийн сангаас олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан.
2. Эрдэнэбулган сумын Засаг даргын 2024 оны "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" А/107 тоот захирамжаар улс төрийн албан хаагчдад 5,472.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллага нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 380,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 263,536.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2024 онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагаа, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, хүүхэд хамгаалал, бусад хөрөнгө, орон нутгийн нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх, ахмадын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа, хөдөлмөр эрхлэлт, улсын баяр наадам гэсэн нийт 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2,516,507.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөв байгууллагын өөрийн орлогоор 49,981.0 мянган төгрөг төвлөрүүлэн, гүйцэтгэлээр 2,371,830.7 мянган төгрөгийг зарцуулж, 194,657.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийн төлөвлөлтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын ЗДТГ нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 1 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, 2 арга хэмжээ 40 хувь, 29 арга хэмжээ 70 хувь, 60 арга хэмжээг 100 хувь биелүүлж, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 90 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,523,674.00	59,101,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,212,709.00	40,411,200.00
354	Хангамжийн материал	38,212,709.00	40,411,200.00
3541	Бичиг хэргийн материал	4,264,570.00	1,999,000.00
3542	Аж ахуйн материал	13,010,779.00	13,947,700.00
3544	Түлш, шатах тослох материал	7,088,000.00	5,700,000.00
3545	Барилгын засварын материал	399,360.00	-
3547	Бусад хангамжийн материал	13,450,000.00	18,764,500.00
36	НӨӨЦИЙН БАРАА	40,310,965.00	18,690,000.00
361	Барааны нөөц	630,000.00	630,000.00
363	Тэжээлийн нөөц	39,680,965.00	18,060,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,429,874,102.94	1,441,876,203.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,429,874,102.94	1,441,876,203.00
392	Биет хөрөнгө	1,383,410,602.94	1,395,660,203.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	729,882,781.88	803,502,495.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-69,909,366.74	-89,094,139.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	110,694,800.00	110,731,646.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,651,353.87	-86,344,444.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110,217,079.60	81,889,241.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,157,660.52	-55,441,846.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,787,092.68	34,256,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,831,389.40	-33,025,237.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	647,155,472.52	668,637,120.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	-411,467,395.21	-460,141,175.46
39216	Дуусаагүй барилга, байгууламж	420,690,542.00	420,690,542.00
393	Биет бус хөрөнгө	46,463,500.00	46,216,000.00
39301	Програм хангамж	1,237,500.00	1,237,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-990,000.00	-1,237,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	46,216,000.00	46,216,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,508,397,776.94	1,500,977,403.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,508,397,776.94	1,500,977,403.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,508,397,776.94	1,500,977,403.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	465,703,585.08	465,703,585.08
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	465,703,585.08	465,703,585.08
51101	Өмч: - төрийн	465,703,585.08	465,703,585.08
512	Хуримтлагдсан үр дүн	1,041,129,621.86	1,033,709,247.92
5121	Өмнөх үеийн үр дүн	1,041,129,621.86	1,041,129,621.86
5122	Тайлант үеийн үр дүн	-	-7,420,373.94
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,564,570.00	1,564,570.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,508,397,776.94	1,500,977,403.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,296,247,234.00	2,700,549,682.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	751,108,192.00	172,578,104.00
120	Нийтлэг татварын бус орлого	751,108,192.00	172,578,104.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,851,250.00	49,981,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,851,250.00	49,981,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	665,576,542.00	92,531,704.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	56,680,400.00	30,065,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,545,139,042.00	2,527,971,578.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,952,142.00	8,889,617.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,952,142.00	4,889,617.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,492,186,900.00	2,519,081,961.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,492,186,900.00	2,519,081,961.93
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,802,318,345.65	2,673,294,548.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,802,318,345.65	2,462,809,648.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,170,252.13	2,214,341,887.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,186,752.13	1,218,895,971.35
210101	Үндсэн цалин	488,569,617.43	667,071,712.90
210102	Нэмэгдэл	243,555,647.68	378,441,389.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,625,853.34	93,599,368.68
210104	Урамшуулал	75,435,633.68	51,783,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	28,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,139,308.00	150,219,000.00
210201	Тэтгэврийн даатгал	76,806,510.53	102,149,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,792,496.72	12,017,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,003,059.22	8,933,530.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,682,365.05	3,083,969.67
210205	Эрүүл мэндийн даатгал	16,854,876.48	24,035,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,002,672.33	95,367,656.35
210301	Гэрэл, цахилгаан	8,382,144.33	19,934,614.00
210302	Түлш, халаалт	66,545,659.00	65,905,242.00
210303	Цэвэр, бохир ус	8,074,869.00	9,527,800.35
2104	Хангамж, бараа материалын зардал	30,871,230.02	44,477,465.00
210401	Бичиг хэрэг	13,229,600.00	14,019,020.00
210402	Тээвэр, шатахуун	9,999,923.00	9,998,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,641,707.02	10,655,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	4,489,535.00
210408	Бараа материал акталсны зардал	-	5,314,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,588,990.00	17,506,239.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	450,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	210,000.00	-
210604	Урсгал засвар	9,928,990.00	17,506,239.00
2107	Томилолт, зочны зардал	3,985,000.00	6,800,000.00
210702	Дотоод албан томилолт	3,985,000.00	6,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,918,389.00	23,770,246.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,131,642.00	21,463,246.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	281,972.00	252,812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	206,800.00
210807	Газрын төлбөр	2,949,775.00	1,847,388.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	338,477,910.65	657,305,310.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	225,499,178.00	547,425,748.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,690,000.00	7,894,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,288,732.65	101,984,861.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	282,148,093.52	248,467,760.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,123,500.00	53,609,982.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,147,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	23,609,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,975,900.00	30,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	201,024,593.52	194,657,777.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,024,593.52	194,657,777.80
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	200,001.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	200,001.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	210,484,900.00
	Дотоод эх үүсвэрээр	-	210,484,900.00
221001	Их засвар	-	186,064,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	24,420,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,493,928,888.35	27,255,134.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	783,244,954.00	34,675,508.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		34,675,508.16
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	783,244,954.00	-
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-783,244,954.00	-34,675,508.16
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	710,683,934.35	-7,420,373.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,573,990,292.00	2,575,378,117.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,851,250.00	49,981,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,851,250.00	49,981,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,851,250.00	49,981,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,851,250.00	49,981,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,545,139,042.00	2,525,397,117.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,952,142.00	8,889,617.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,952,142.00	4,889,617.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,492,186,900.00	2,516,507,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,492,186,900.00	2,516,507,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,691,754,038.00	2,311,336,913.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,691,754,038.00	2,311,336,913.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,409,605,944.48	2,062,869,152.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,186,752.13	1,218,895,971.35
210101	Үндсэн цалин	488,569,617.43	667,071,712.90
210102	Нэмэгдэл	243,555,647.68	378,441,389.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,625,853.34	93,599,368.68
210104	Урамшуулал	75,435,633.68	51,783,500.00
210105	Гэрээт ажлын хөлс		28,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,139,308.00	150,219,000.00
210201	Тэтгэврийн даатгал	76,806,510.53	102,149,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,792,496.72	12,017,200.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,003,059.22	8,933,530.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,682,365.05	3,083,969.67
210205	Эрүүл мэндийн даатгал	16,854,876.48	24,035,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,090,672.33	93,979,656.35
210301	Гэрэл, цахилгаан	8,382,144.33	19,934,614.00
210302	Түлш, халаалт	73,633,659.00	64,517,242.00
210303	Цэвэр, бохир ус	8,074,869.00	9,527,800.35
2104	Хангамж, бараа материалын зардал	29,506,860.02	36,875,495.00
210401	Бичиг хэрэг	11,929,070.00	11,753,450.00
210402	Тээвэр, шатахуун	9,999,923.00	9,998,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,641,707.02	10,655,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,936,160.00	4,467,635.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,077,520.00	16,716,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,705,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	915,840.00	1,770,000.00
210604	Урсгал засвар	9,456,680.00	14,946,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,985,000.00	6,800,000.00
210702	Дотоод албан томилолт	3,985,000.00	6,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,278,389.00	23,770,246.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,491,642.00	21,463,246.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	281,972.00	252,812.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	206,800.00
210807	Газрын төлбөр	2,949,775.00	1,847,388.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,341,443.00	515,612,483.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,289,743.00	506,664,783.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,051,700.00	8,947,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	282,148,093.52	248,467,760.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,123,500.00	53,609,982.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,147,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		23,609,982.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,975,900.00	30,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	201,024,593.52	194,657,777.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,024,593.52	194,657,777.80
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		200,001.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		200,001.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	882,236,254.00	264,041,204.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	882,236,254.00	264,041,204.00
	Дотоод эх үүсвэрээр	882,236,254.00	264,041,204.00
221001	Их засвар	-	215,576,204.00
222001	Тоног төхөөрөмж	-	24,420,000.00
223001	Бусад хөрөнгө	783,244,954.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	98,991,300.00	24,045,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-882,236,254.00	-264,041,204.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	330,445,687.51	797,713,842.59
7	Тайлант үеийн үр дүн	-	-	710,683,934.35	710,683,934.35
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	1,041,129,621.86	1,508,397,776.94
17	Тайлант үеийн үр дүн	-	-	-7,420,373.94	-7,420,373.94
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,703,585.08	1,564,570.00	1,033,709,247.92	1,500,977,403.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,547,507,300.00	2,371,830,722.20	175,676,577.80	92.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,167,507,300.00	2,108,294,518.20	59,212,781.80	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,126,205,300.00	2,054,684,536.20	51,520,763.80	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,221,755,000.00	1,218,895,971.35	2,859,028.65	99.8
210101	Үндсэн цалин	677,056,400.00	667,071,712.90	9,984,687.10	98.5
210102	Нэмэгдэл	376,691,100.00	378,441,389.77	-1,750,289.77	100.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,224,000.00	93,599,368.68	-5,375,368.68	106.1
210104	Урамшуулал	51,783,500.00	51,783,500.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	28,000,000.00	28,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,218,800.00	150,219,000.00	-200	100.0
210201	Тэтгэврийн даатгал	102,149,200.00	102,149,200.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	12,017,000.00	12,017,200.00	-200	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,614,000.00	8,933,530.33	680,469.67	92.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,403,500.00	3,083,969.67	-680,469.67	128.3
210205	Эрүүл мэндийн даатгал	24,035,100.00	24,035,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,000,000.00	93,979,656.35	6,020,343.65	94.0
210301	Гэрэл, цахилгаан	25,000,000.00	19,934,614.00	5,065,386.00	79.7
210302	Түлш, халаалт	85,000,000.00	64,517,242.00	20,482,758.00	75.9
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	9,527,800.35	472,199.65	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	38,874,900.00	37,380,495.00	1,494,405.00	96.2
210401	Бичиг хэрэг	12,000,000.00	11,753,450.00	246,550.00	98.0
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	9,998,650.00	1,350.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,874,900.00	10,655,760.00	1,219,140.00	89.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,972,635.00	27,365.00	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	16,716,300.00	283,700.00	98.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,770,000.00	230,000.00	88.5
210604	Урсгал засвар	15,000,000.00	14,946,300.00	53,700.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	6,800,000.00	1,200,000.00	85.0
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	6,800,000.00	1,200,000.00	85.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,356,600.00	20,950,630.00	6,405,970.00	76.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,223,500.00	18,643,630.00	5,579,870.00	77.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	-	500,000.00	-
210804	Татвар	350,000.00	252,812.00	97,188.00	72.2

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	206,800.00	93,200.00	68.9
210807	Газрын төлбөр	1,983,100.00	1,847,388.00	135,712.00	93.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	543,000,000.00	509,742,483.50	33,257,516.50	93.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	523,000,000.00	500,794,783.50	22,205,216.50	95.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000,000.00	8,947,700.00	11,052,300.00	44.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,302,000.00	53,609,982.00	7,692,018.00	87.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,302,000.00	53,609,982.00	7,692,018.00	87.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,302,000.00	23,609,982.00	7,692,018.00	75.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	380,000,000.00	263,536,204.00	116,463,796.00	69.4
	Дотоод эх үүсвэрээр	380,000,000.00	263,536,204.00	116,463,796.00	69.4
221001	Их засвар	325,000,000.00	215,576,204.00	109,423,796.00	66.3
222001	Тонг төхөөрөмж	55,000,000.00	47,960,000.00	7,040,000.00	87.2
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,547,507,300.00	2,371,830,722.20	175,676,577.80	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,516,507,500.00	2,321,849,722.20	194,657,777.80	
132001	Орон нутгийн төсвөөс	2,516,507,500.00	2,321,849,722.20	194,657,777.80	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	31,000,000.00	49,981,000.00	-18,981,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,000,000.00	49,981,000.00	-18,981,000.00	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
3	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	48	4	92.31
6	Удирдах ажилтан	4	3	1	75.00
7	Гүйцэтгэх ажилтан	9	31	-22	344.44
8	Үйлчлэх ажилтан	21	11	10	52.38
9	Гэрээт ажилтан	18	3	15	16.67

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,889,617.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,889,617.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,689,616.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,819,616.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,819,616.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,870,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,870,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,001.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	200,001.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,889,617.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,889,617.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,889,617.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй. Харин залруулаагүй 37,777.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч 2,850.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 34,927.2 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 37,777.2 мянган төгрөг бөгөөд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,832.9 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Бараа материалыг нярвын тайлан, анхан шатны баримтаас хөөн хянаж үзэхэд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,850.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй бараа материал бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

3.2.1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын зардлыг хянаж үзэхэд сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджаар тооцолгүйгээр Эрдэнэбулган сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/40 дүгээр захирамжаар ЗДТГ-ын даргад 744.3 мянган төгрөгийн, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны А/11 дүгээр тушаалаар төсөв төрийн сангийн мэргэжилтэнд 467.9 мянган төгрөгийн, санхүү албаны даргад 799.4 мянган төгрөгийн, МАА үйлдвэрлэл, төлөвлөлт, менежмент малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 407.5 төгрөгийн, нийт 2,399.1 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг дутуу тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.5-д "... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-д "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн заасныг баримтлан тухайн төрийн захиргааны албан хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг хянаж үзэхэд Эрдэнэбулган сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" А/107 дугаар захирамжаар засаг даргын орлогч болон 7 багийн засаг даргад сарын үндсэн цалингийн 40-50 хувиар тооцож, үр дүнгийн урамшуулалд нийт 5,472.5 мянган төгрөгийг олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57.2.1-т зааснаар “улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", үүнд 15.1.3 "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

3.2.3. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг хянаж үзэхэд Эрдэнэбулган сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн "Албан хаагчдад шагнал олгох тухай" Б/172 дугаар захирамжаар 9 албан хаагчид нийт 19,133.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", үүнд 15.1.3 "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

3.2.4. Урсгал зардлыг хянаж үзэхэд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,053.0 мянган төгрөгөөр ханын зураг худалдан авсан, шуудан холбооны зардлаас 2,740.0 мянган төгрөгийг камержуулалтын ажилд, нийт 3,793.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

3.2.5. Тайлант онд нягтлан бодогчид ТҮМ-6 шатлалаар үндсэн цалинг тогтоож, сар бүр 71.0 мянган төгрөгийн үндсэн цалингийн зөрүү үүсгэж, нийт 1,249.6 мянган төгрөгийн цалин нэмэгдэл урамшууллыг дутуу тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.5-д "..., төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний байгууллагын мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэг, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын ТҮМ-7 ангилалд ..., ерөнхий нягтлан бодогч хамаарна " гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3.2.6. Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулалтыг хянаж үзэхэд Эрдэнэбулган сумын нэгдсэн шинэ жилийн баярын арга хэмжээг зохион байгуулахад нийт 2,880.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 -д " Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион

байгуулах", 4.2.6-д "Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Төсвийн үлдэгдлийг төвлөрүүлээгүй БМ бэлтгэсэн	1	2850.0	1	2850.0						
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг дутуу тооцож олгосон	1	2399.1			1	2399.1				
Цалингийн сангаас шагнал олгосон	1	19133.0			1	19133.0				
Улс төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	1	5472.5			1	5472.5				
Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн	1	3793.0			1	3793.0				
Цалин дутуу тооцож олгосон	1	1249.6			1	1249.6				
Төрийн хэмнэлтийг хууль зөрчсөн	1	2880.0			1	2880.0				
Нийт	7	37777.2	1	2850.0	6	34927.2				